



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, батлан, хянахгүй байгаа нь батлагдсан санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг дагуулж байна.

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор
Б.Наранчимэг

Аудитор
Ж.Цогт

Аудитын
тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл гарвал
70362442, 70363036,
70363040 дугаарын
утас, 70363040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ
аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

2017 оны 10 дугаар
сар

Товчилсон үгийн тайлбар

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Үндсэн мэдээлэл**

1. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна уу?

1.1 Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиг үүрэг хэрхэн хэрэгжиж байна вэ?

1.2 Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлж байна уу?

1.3 Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт хэрхэн тогтоож байна вэ?

1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг хэрхэн татан оролцуулж байна вэ?

1.5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт үр дүнтэй зохион байгуулагдаж байна уу?

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байна уу?

2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байна уу?

2.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын уялдаа холбоо болон давхардсан, орхигдуулсан чиг үүргүүд байна уу?

2.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа үр дүнтэй байна уу?

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байна уу?

3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө хуульд заасан хэмжээнд төлөвлөгдөж байна уу?

3.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилт холбогдох хуулиудад нийцэж байна уу?

3.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байна уу?

3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хэрхэн явагдаж байна вэ?

Илрүүлсэн зөрчил

Дүгнэлт

Зөвлөмж

Хавсралт судалгаа

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НХҮХ	Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс
ХГБХХ	Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
БСГ	Боловсрол соёлын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ОНХ	Олон нийттэй харилцах
ААН	Аж ахуйн нэгж
ТББ	Төрийн бус байгууллага
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ДЗОУБ	Дэлхийн зөн олон улсын байгууллага

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт УАГ-аас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

2. Аудитын зорилт

Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна уу?
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байна уу?
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байна уу?

3. Аудитын хамарсан хүрээ

Аудитад Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар зэрэг хууль сахиулах байгууллагууд, аймаг, сумдын ИТХ, ГХУСАЗЗ зэрэг байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2015-2016 он, 2017 оны эхний 9 сарын үйл ажиллагааны болон санхүүгийн баримт, тайлан, зардлын төлөвлөлт, гүйцэтгэл зэргийг хамруулав.

4. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай нотлох баримт, лавлагаа тайлбар, асуулга авах, судалгаа, тайлан мэдээг холбогдох байгууллагуудаас гаргуулж шинжлэн судалж, давтан тооцоолол хийх, тулган баталгаажуулах зэрэг арга зүй, горимыг хэрэгжүүлэв.

Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

5. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль,
- Цагдаагийн албаны тухай хууль,
- Прокурорын тухай хууль,
- Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль,
- Захиргааны хариуцлагын тухай хууль,
- Захиргааны ерөнхий хууль,
- Замын хөдөлгөөний дүрэм,

- Иргэний хууль,
- Эрүүгийн хууль,
- Прокурорын байгууллагын тухай хууль,
- Гэр бүлийн тухай хууль,
- Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хууль,
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
- Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжууд болон холбогдох бусад хууль эрхийн актууд

6. Үндсэн мэдээлэл

УИХ-аас 1997 онд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” баталсан бөгөөд 2012 оны 01 дүгээр сарын 19, 2013 оны 07 дугаар сарын 05, 2015 оны 12 дугаар сарын 04, 2016 оны 12 дугаар сарын 22, 2017 оны 05 дугаар сарын 18-нд буюу нийт 5 удаа уг хуульд өөрчлөлт оруулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дараах үндсэн чиглэлээр зохион байгуулж хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

1. *Гэмт хэргийн талаарх мэдээллийг цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоох;*
2. *Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх;*
3. *Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоох;*
4. *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэр харгалзахгүй татан оролцуулах;*
5. *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах.*

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль сахиулах, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэд оролцсон өргөн цар хүрээтэй ажил байхаар хуульчлагдсан бөгөөд аймгийн хувьд бүх шатны ИТХ, Цагдаагийн газар, Прокурорын газар, аймаг сумдын ГХУСАЗЗ зэрэг байгууллагууд голлох байр суурьтай оролцож байна.

Аудитад хамрагдсан хугацаанд аймаг, сумдын ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаанд нийт 232.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, 188.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бүлэг 1

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна үү?

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

1.1. Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиг үүрэг хэрхэн хэрэгжиж байна вэ?

Аймгийн Цагдаагийн газрын “Судалгаа, дүн шинжилгээний баг” гэмт хэрэг гарч буй шалтгаан, нөхцөлийг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 10 дугаар зүйлийн 1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.1.1 дэх заалтыг үндэслэн Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2013 оны 04-р сарын 15-ны өдрийн 229 дугаар тушаалаар гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах үүрэг бүхий судалгаа, дүн шинжилгээний багийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг баталжээ.


Уг тушаалын дагуу аймгийн Цагдаагийн газрын даргын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 57 дугаар тушаалаар “Судалгаа, дүн шинжилгээний баг”-ийг Цагдаагийн газрын дэд даргаар ахлуулсан, 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд 2015 оны 05-р сарын 15-ны өдрийн 62 дугаар тушаалаар багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан байна.

Судалгаа, дүн шинжилгээний баг нь гарсан гэмт хэрэг, зөрчлийн байдалд судалгаа хийж, тайлан дүнг ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төв, Сэлэнгэ аймгийн ГХУСАЗЗ-д танилцуулж, цаашид авах арга хэмжээ, анхаарах асуудлын талаар чиглэл өгч ажиллаж ирсэн байна.

Аудитад хамрагдсан 2015-2016 он, 2017 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 2046 гэмт хэрэг үйлдэгдсэнээс 36.5 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 24.7 хувийг хулгайн гэмт хэрэг, 12.1 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын гэмт хэрэг, 26.7 хувийг бусад гэмт хэрэг эзэлж байна. / гэмт хэргийн тоо, төрлийг хавсралт 1-ээр дэлгэрэнгүйгээр харуулав /

Аудитад хамрагдсан хугацаанд нийт 7283 хүн эрүүлжигдэж, нийт гэмт хэргийн 36,0 хувийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна.

/Гэмт хэргийн өсөлт, бууралтыг графикаар харуулбал/



Дээрх тоо, мэдээллээс харахад аудитад хамрагдсан хугацаануудад нийт үйлдэгдсэн гэмт хэрэгт хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 30,5-39,9 хувийг, хулгайн гэмт хэрэг 23,4-26,2 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр бөгөөд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын гэмт хэргийн тоо нэмэгдэх хандлагатай байна.

Судалгаа дүн шинжилгээний баг нь гэмт хэрэг гарч байгаа нөхцөл шалтгаан, шинж чанарт судалгаа, шинжилгээ хийснээр гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан нөхцөлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Архидалт ихэссэн,
- Тээврийн хэрэгсэлийн тоо нэмэгдэж, замын хөдөлгөөн ихэссэн, хөдөлгөөнд тавих хяналт, ажиллах хүн хүч, техник хэрэгсэл дутмаг,
- Төсөв мөнгөний хүрэлцээгүй,
- Сумдын ГХУС зөвлөлийн ажил хангалтгүй,
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, харуул хамгаалалт, сонор сэрэмж сул,
- Алсдагдсан газруудад гэрэлтүүлэггүй, хяналтын камерын хүрэлцээ дутмаг,
- Ажилгүйдэл, ядуурал өссөн,

1.2 Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байна уу?

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөн, гүйцэтгэж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах болон гэмт хэрэг гарч буй шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хууль сахиулах байгууллагууд тодорхой ажлуудыг хийхээр төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Аймгийн Цагдаагийн газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр 2015 онд 36 ажил, 2016 онд 42 ажил, 2017 оны 3-р улирлын байдлаар 32 ажил төлөвлөн, гүйцэтгээд байна.
Аудитад хамрагдсан онуудад Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь заалтын хүрээнд Цагдаагийн газрын даргын зөвлөлийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг батлагдсан хуваарийн дагуу 17 сум 3 тосгоны оршин суугчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

чиглэлээр зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 27198 иргэн, 71 байгууллага аж ахуйн нэгж хамрагдсан байна.

Цагдаагийн газраас цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан нэгдсэн болон хэсэгчилсэн тусгай арга хэмжээнүүдийг төлөвлөн, амжилттай хэрэгжүүлж иржээ. Тухайлбал “Сар шинэ”, “Хяналт”, “Хаягжуулалт”, “Тулгалт”, “Цохилт”, “Нойтон нарс”, “Үүрэг чиглэл”, “Санамж сэрэмжлүүлэг”, “Соётуу”, “Хорт зуршил хяналт”, “Архи, тамхигүй ирээдүй”, “Хонх”, “Цахим тоглоом”, “Эрчимжүүлэлт”, “Морин эргүүл-2016”, “Хаягжуулалт”, “Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн болон хорих ангиас суллагдсан этгээдүүдэд хяналт тавих 45 хоногийн аян”, “Бичиг баримт”, “Мөр”, “Ургац”, “Хичээлийн шинэ жил”, “Сэрэмжлүүлэг-2016”, “Оюутан-Тээвэр”, “Хөдөлгөөнт эргүүл”, “Хамгаалах бүс”, “Хамгаалалтын суудал” “Хулгай”, “Илрүүлэлт”, “Оргодол”, “Зөрчлийн илрүүлэлт”, “Галт зэвсэг 2016”, “Хулгай 2016”, “Мал 2016” зэрэг нэгдсэн -42, тусгай 11, хэсэгчилсэн-23 зэрэг арга хэмжээг удирдамж, төлөвлөгөөний хүрээнд зохион явуулж, үр дүнг тооцон ажиллажээ.

- Аймгийн Прокурорын газар нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр жил бүр 28 ажил төлөвлөн, хэрэгжүүлсэн байна. Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажилд прокурор, туслах ажилтнуудыг жигд оролцуулах зорилт тавьж, томоохон аж ахуйн нэгж, байгууллага сумдыг хариуцуулан, хэвлэл мэдээлэлд тогтмол мэдээ, мэдээлэл өгчээ. 2017 онд хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, судалгааны дүнгийн талаар аймаг, сумдын ГХУСАЗЗ-д танилцуулжээ. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийг олон нийтэд таниулах, “Хүчирхийлэлд үгүй гэж хэлье”, “Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон” аяныг тус тус зохион байгуулан, үр дүнг тооцон ажилласан байна. Эрүүгийн хууль, Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуулиар аж ахуйн нэгж, албан тушаалтанд 10 цагийн сургалт зохион байгуулж, цахим хуудсанд 16 мэдээлэл байршуулсан байна.

1.3 Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт хэрхэн тогтоож байна вэ?

Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоон ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйл¹ -ийн дагуу аймгийн Цагдаагийн газраас 2015-2016 он, 2017 оны эхний 9 сард шүүхээс тэнсэн суллагдсан 242, хорих ялаас тэнсэн харгалзсан 95, насанд хүрээгүй учир ял хойшилсон 11, хорих ялаас суллагдсан 7, 3 нас хүртэлх хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг 2 зэрэг нийт 360 хүнд захиргааны хяналт тавьж ажилласан байна. Үүнийг он тус бүрээр хүснэгтээр харуулбал:

¹ Эрүүгийн хуулийн 6.12, 6.13 дугаар зүйлд зааснаар хугацаанаас өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн, 12.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг, 13.1, 13.3, 15.5, 19.9, 21.2 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж 5 жилээс дээш хугацаагаар хорих ял эдэлж суллагдсан бол дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс нь урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтооно.

Захиргааны хяналтанд байгаа ялтны тоо

Төрөл зүйл анги	2015	2016	2017.09 сар	нийт
Шүүхээс тэнсэн суллагдсан	15	119	108	242
Хорих ялаас тэнсэн харгалзсан	44	27	24	95
Насанд хүрээгүй учраас ял хойшилсон	2	6	3	11
Хорих ялаас суллагдсан	7			7
3 нас хүртэлх хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг		3	2	5
НИЙТ	68	155	137	360

2015 онд Өршөөлийн хуулийн дагуу захиргааны хяналтад байсан 200 ялтан өршөөлд хамрагдснаас тоо буурсан үзүүлэлттэй байна.

Захиргааны хяналтад байгаа ялтан болон тэдний гэр бүлийн хүмүүстэй харьяа хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгчид сар бүр уулзалт хийх, ажилд зуучлах, ажил байдалтай нь танилцах зэргээр хяналт тавьснаар 2015-2016 онд нэг ч ялтан гэмт хэрэгт дахин холбогдоогүй бол 2017 онд шүүхээс тэнсэн суллагдсан 1 ялтан гэмт хэрэг үйлдсэн байна.

Захиргааны хяналтад байгаа ялтнуудад жил бүр “Архидан согтуурах, түүний хор уршиг”, “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Захиргааны хяналт” сэдвүүдээр сургалт зохион байгуулж, баяр ёслолын өдрүүдэд гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдохгүй байх талаар баталгаа гаргуулжээ.

2015 онд “Хорих ял хугацааны өмнө тэнсэн суллагдсан болон хорих ял нь тэнсэгдсэн этгээдэд тавих хяналтыг сайжруулах 45 хоногийн аян” зохион байгуулж, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гарган, батлуулан биелэлтэд хяналт тавин ажилласан байна.

Захиргааны хяналтыг тавьсан хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгчид сар бүр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан, илтгэлийг аймгийн Цагдаагийн газрын олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагчид өгч, дүн мэдээг нэгтгүүлэн ажиллаж байна.

1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг хэрхэн татан оролцуулж байна вэ?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг татан оролцуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1.1², 1.2³-д заасны дагуу аудитад хамрагдсан хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг дараах хэлбэрээр татан оролцуулсан байна. Тухайлбал:

- Нийтийг хамарсан баяр ёслол, амралтын өдрүүдэд иргэдийг цагдаагийн ажилтнуудтай хамтарсан нийтийн эргүүлд 2015 онд 11 удаа, 2016 онд 14 удаа, 2017 оны 09-р сарын байдлаар 8 удаа гаргаж ажиллуулсан байна.
- Аймгийн Цагдаагийн газраас ГХУСАЗЗ-тэй хамтран Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллуулах хүний тоог 16-р тогтоосны дагуу 2015 онд 7 суманд ажиллуулан ,

² Иргэдийг нийтийн эргүүлд гаргах

³ Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр томилох

аймгийн Цагдаагийн газраас үр дүнг үнэлсний үндсэн дээр сард тус бүр 300,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Олон нийтийн цагдаагийн зүгээс хариуцсан сум, багийн нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, өмчийн хулгай, мал хулгайлах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг иргэдэд хүргэн ажиллаж иржээ.

- Аймгийн Цагдаагийн газраас сум, баг, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор гадна орчноо гэрэлтүүлэгтэй болгох, камержуулах талаар зөвлөмж чиглэл өгч, 87 аж ахуйн нэгж гадна орчноо өөрийн хөрөнгөөр камержуулсан байна.
- Аймгийн Хүүхдийн хууль зүйн хороо, Халамжийн хэлтэс, Сүхбаатар сумын ЗДТГ, албан бус боловсролын Гэгээрэл төв, аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулан, хэрэгжүүлсэн байна.
- Сургуулийн орчинд бага насны сурагчдыг хуурч мэхлэн, эд зүйлийг булаан авах, дээрэмдэх, айлган сүрдүүлэх, зодох, гэмтээх зэрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ЕБС-ийн захирлын тушаалаар эргүүлд ажиллах багш нарыг томилж, сургуулийн орчинд багш, эцэг эх, сурагчдын хамтарсан эргүүлийг тогтмол зохион байгуулж байна.
- Аймгийн ГХУСАЗЗ, Цагдаагийн газраас хамтран “Архи, тамхигүй орчинг бүрдүүлсэн хамт олон болох” уриалгыг аймгийн хэмжээнд дэвшүүлж, 32 аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэн, уриалгын дагуу идэвхтэй оролцохыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилжээ.

1.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт үр дүнтэй зохион байгуулагдаж байна уу?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалтуудыг олон тоогоор зохион байгуулж байгаа ч гэмт хэргийн тоо дорвитой хэмжээгээр буурахгүй байна.

Аудитад хамрагдсан хугацаанд хууль сахиулах байгууллагуудын зүгээс дараах сургалт, сурталчилгааны ажлуудыг төлөвлөн, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн Хууль зүйн туслалцааны төв, ХЗЯ-тай хамтран “Архины хор нөлөө, түүнээс сэргийлэх нь” сэдэвт сургалтад 40 иргэнийг хамруулсан байна.
- “Сэлэнгэ амьдрах сайхан” ТББ-тай хамтран захиргааны журмаар баривлагдсан хүмүүст сар бүр “Архи ба амьдрал”, “Архи ба тархи” сэдвүүдээр нөлөөллийн сургалтыг зохион байгуулж хэвшжээ.
- “Эрүүл идэвхтэй амьдрал” клубтэй хамтран Сүхбаатар суманд оршин суудаг архинд хамааралтай 10 хүнийг 2 цагийн сургалт, ярилцлагад хамруулж, Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг 11 байгууллагын ажилтан, алба хаагчдад архины эсрэг сэдэвчилсэн сургалтуудыг зохион явуулсан байна.
- Саатуулах байрны эмч нар “Таны амьдралд архинаас үүдэн гарах хохирол” сэдвээр сургалтыг тогтмол зохион байгуулж байна.

- ЕБ-ийн 6 сургуулийн сурагчдад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай шинэчилсэн хуулиар сургалт зохион байгуулж, 2 төрлийн 2000 ширхэг санамж, сэрэмжлүүлгийг хэвлүүлэн тарааж, яриа таниулга хийж, зөвлөгөө өгчээ.
- Шинэчилсэн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, “Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам”-аар яриа, таниулгыг аймгийн “Миний Монгол” Катв-ээр 1 удаа хийж, 3 удаагийн давтамжаар нэвтрүүлж, иргэдэд хүргэсэн байна.
- Аймгийн ЗДТГ-ын хуулийн хэлтэстэй хамтран Сүхбаатар суманд “Хүчирхийллийн эсрэг хамтдаа” сургалт, өдөрлөгийг зохион байгуулж, “Гэр бүл хүүхдийн эсрэг хүчирхийлэл”, “Монгол улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хууль эрх зүйн орчин”, “Хэрхэн сайн эцэг, эх байх вэ”, “Хүн худалдах гэмт хэрэг ба хууль эрх зүйн орчин”, “Насанд хүрээгүй хүмүүс ба хуулийн хариуцлага”, “Бэлгийн дарамт ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” сэдэвт сургалтуудыг нийт 1166 сурагч, эцэг, эх асран хамгаалагч нарт, оролцооны клубын бүлгийн 35 хүүхдийг хамруулан “Бидний үгийг сонсооч” хэлэлцүүлэг, Сүхбаатар сумын 2-р сургуулийн 75 охидод “Гэр бүл хүүхдийн эсрэг хүчирхийлэл”, аливаа эрсдлээс өөрийгөө болон найз нөхдөө хэрхэн хамгаалах сэдвээр уулзалт, ярилцлагыг зохион байгуулсан байна.
- Хүүхдүүдээс гаргасан саналын дагуу “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл”, “Кибер дарамт ба цахим гэмт хэрэг”, “Охид, эмэгтэйчүүдийн бэлгийн дарамт” сэдвээр сургалтын хөтөлбөрийг боловсруулан, аймгийн Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, ДЗОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран 18 сургууль, 8 суманд сургалт зохион байгуулж, нийт 5980 сурагч, 256 багшийг хамруулсан байна.
- Сүхбаатар сумын 7 сургуулийн захирал, нийгмийн ажилтан, хүүхдийн хууль зүйн хорооны ажилтан, сумын нийгмийн ажилтан, багийн цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг хамруулан “Айдасгүй сургууль” зөвлөгөөнийг зохион байгуулжээ.
- Хүүхэд, эмэгтэйчүүд болон иргэдийг аливаа хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй хүчирхийлэлтэй тэмцэх, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль, Хүний эрхийн үндэсний комиссын 2012 оны 3/08 дугаартай зөвлөмжийг хэрэгжүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийн үйлдлийг таслан зогсоох, зан үйлд нөлөөлөх зорилготой “Би гэр бүлдээ хайртай” нөлөөллийн сургалтыг үе шаттай зохион байгуулж, сургалтад байнга архидан согтуурч, гэр бүлдээ түгшүүр төрүүлдэг, удаа дараа эрүүлжүүлэгдсэн 156 иргэн, захиргааны хяналттай 42 иргэнийг хамруулсан байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн талаарх иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл”, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт сургалт, сурталчилгаа, фокус ярилцлага, архины хамааралтай иргэдийг хамруулсан нөлөөллийн сургалт, багийн иргэдийн дунд “Та үүнийг мэдэх үү?”, “Өөрчлөлтийг өөрсдөөсөө эхэлье” сэдэвт хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан байна.
- Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад “Тамхины хяналтын тухай хууль”-ийг сурталчлах, иргэд олон нийтэд мэдээлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор орон нутгийн “Миний Монгол”, “Таны сэлэнгэ” Катв-үүдээр тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, “Тамхигүй орчин бидний

ирээдүй”, “Тамхины хор уршиг” сэдвүүдээр 6 удаа иргэдэд мэдээлэл өгч, орон нутгийн телевизээр өдөрт 12 удаагийн давтамжтай үгэн зар байршуулан ажиллажээ

- Монгол улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлигийн хүрээнд “Ээлтэй үйлчилгээ-Иргэн танд” уриан дор Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалтыг тогтмол зохион байгуулж байгаа боловч үр дүн хангалтгүй, тухайлбал согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, хулгайн гэмт хэргийн тоо дорвитой буурахгүй байна.

Бүлэг 2

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга, хэлбэр үр дүнтэй байна уу?

Гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий иргэн, нийгмийн эмзэг бүлэгт хандсан арга хэмжээнүүдийг түлхүү хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга, хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна уу?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүйгээр гэмт хэргийн тоо буурах чиг хандлагагүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг :

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах,
- Гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах,
- Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах гэж заасан байдаг.

Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нийтийн эргүүл жижүүр ажиллуулах, хүүхдүүдийг зам тээврийн осол зөрчлөөс хамгаалах зорилгоор сургуулийн орчимд “School police эргүүлийг тогтмол ажиллуулах, иргэдийн сайн дурын нөхөрлөл, бүлгүүдийг зохион байгуулж, ажиллуулах зэргээр иргэдийг татан оролцуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах, мэдээллийг иргэдээс төлбөртэй авах ажлыг хангалтгүй зохион байгуулж, аймгийн ГХУСАЗЗ-ийн төсвөөс 2015-2017 онуудад энэ төрлийн зардал гараагүй байна.

Сумдын хэмжээнд 2015-2017 оны эхний 9 сарын байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулахад ердөө 1.5 сая төгрөг, мэдээллийн төлбөрт 0.4 сая төгрөг зарцуулжээ.

Хууль сахиулах байгууллагууд болон аймгийн ГХУСАЗЗ-ийн зүгээс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон гэмт хэргийн хор хөнөөл, үр дагаврыг сурталчлах сургалтуудыг олон тоогоор зохион байгуулж, ихээхэн хэмжээний хөрөнгө, мөнгө зарцуулж байгаа боловч сургалтуудын дийлэнх нь тодорхой тооны албан тушаалтнуудын хүрээнд хийгдэж, эмзэг бүлгийн иргэд, архидаан согтуурагчид гэх мэт гэмт хэрэгт өртөх, үйлдэх эрсдэл бүхий хүрээг хамарч чадахгүй байгаа байдал ажиглагдаж байна.

Тухайлбал, аймгийн хэмжээний гэмт хэргийн тоо, мэдээнээс харахад нийт гэмт хэрэгт согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувийн жин 2014 онд 31,7 хувь, 2015 онд 37,2 хувь, 2016 онд 37,4 хувь гэх мэтчилэн өсөх хандлагатай болж байхад архидаан согтуурагчдын дунд зохион байгуулсан сургалт сурталчилгаа, тэднийг архидах донгоос салгах эмчилгээ, үйлчилгээ, энэ чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудыг дэмжих чиглэлээр аймгийн ГХУСАЗЗ-ийн төсвөөс 2015-2017 онуудад нэг ч төгрөгийн зардал гаргаагүй байна.

Нөгөө талаас, хууль сахиулах байгууллагуудын зүгээс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай болон нэг бүрчилсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч ажилгүйдэл, ядуурал, архидалтыг бууруулах, ёс суртахуун, хүмүүжил олгох, сайжруулах шинж чанартай ерөнхий арга хэмжээ хангалтгүй байгаагаас гэмт хэргийн тоо дорвитой хэмжээгээр буурахгүй байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд сүүлийн 2 жилд / 2015-2016 он / ажилгүйдлийн түвшин 3.2 хувиар, согтуугаар үйлдсэн гэмт хэргийн тоо 3.3 хувиар өссөн зэргээс үзэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг илүү үр өгөөжтэй болгох, нийгмийн эмзэг бүлэг, гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий иргэдэд хандуулах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн хүмүүжил, ёс зүйг дээшлүүлэх чиглэлийн бодлого баримтлах шаардлагатай байна.

2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын уялдаа холбоо болон давхардсан, орхигдуулсан чиг үүргүүд байна уу?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын давхардсан болон орхигдсон чиг үүрэг байхгүй бөгөөд харин төрийн байгууллагууд чиг үүргээ үр нөлөөтэй гүйцэтгэх шаардлагатай байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 10-р зүйлд “Гэмт хэрэгтэй тэмцэх”, 11-р зүйлд “Нийтийн хэв журам хамгаалах”, 12-р зүйлд “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах”, 13-р зүйлд “Захиргааны хяналт тавих гэсэн чиг үүргийг цагдаагийн байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 2 дугаар бүлэгт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, оролцогчдын эрх, үүргийг оролцогч байгууллага, хуулийн этгээд, иргэд бүрээр хуульчилж өгсөн байдаг.

Хуулийн зүйл, заалтаас үзэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлуудыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын давхардсан болон орхигдсон чиг үүрэг байхгүй гэж дүгнэж байна.

Харин хуулинд заагдсан байгууллага, хуулийн этгээд, иргэдийн зүгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ үр нөлөө бүхий гүйцэтгэж, Засгийн газар, төрийн байгууллагуудын зүгээс гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх улс, орон нутгийн ерөнхий арга хэмжээний бодлогыг зөв тодорхойлж, хэрэгжүүлсэн тохиолдолд гэмт хэргийн гаралт, түүнд өртөгсдийн тоо хэмжээ буурах магадлалтай юм.

2.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа үр дүнтэй байна уу?

Аймгийн ГХУСАЗЗ нь үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16-р зүйлийн 16.3-д ГХУСАЗЗ нь “аймаг, нийслэлийн Засаг дарга болон хууль сахиулах төв байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын тайланг гаргуулж авах”; “төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтны зөвлөлгөөнийг тодорхой хугацаанд зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хэлэлцэн, цаашид авах арга хэмжээг хамтран төлөвлөх”; “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах”; “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах”; “гэмт хэргийн байдал, түүний шалтгаан нөхцөлийн талаархи статистик мэдээг солилцох”; “гэмт хэргийн байдалд хамтран дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээний чиглэлийг тогтоох” зэрэг 8 чиг үүргийг хуульчлан заасан байдаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 , 16.2 -д заасны дагуу Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2009 оны 142 дугаар тогтоолоор аймгийн ГХУСАЗЗ-ийг 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж байсан бол 2014 оны 14 дүгээр, 2015 оны 44 дүгээр тогтоолоор тус тус өөрчлөлт оруулснаар өнөөгийн байдлаар 15 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн ГХУСАЗЗ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 142 дугаар тогтоолоор батлагдсан ” Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн ажиллах журам”-ын хүрээнд үйл ажиллагаа явуулж, аймгийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулах, уг ажлын явц, үр дүнд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилго тавин ажиллаж байна.

Аймгийн ГХУСАЗЗ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд 2015 онд 36, 2016 онд 30, 2017 онд 32 ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхээр тусгаж, ГХУСАЗЗ-ийн хурлаар баталсан байна.

Төлөвлөгөөний биелэлтийг аудитын явцад заалт бүрээр нэг бүрчлэн гаргуулахад 2015 онд 83.3 хувь, 2016 онд 83.3 хувь, 2017 оны 3-р улирлын байдлаар 93.8 хувиар биелэсэн гэж тайлагнасан байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 01

№	Хийх ажлууд	2015		2016		2017	
		төлөв	биелэлт	төлөв	биелэлт	төлөв	биелэлт
1	Бодлого зохицуулалт, ажлын уялдааг хангах	13	10			15	14
2	Зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудал	8	7	7	5		
3	Хяналт шалгалтын ажлын талаар	6	5	6	4	8	8
4	Хууль сахиулах байгууллагуудын хамтран ажиллах			8	7		
5	Хууль,эрх зүйн сургалт, сурталчилгаа хийх	9	7	9	9	9	8
	НИЙТ	36	29	30	25	32	30
	Биелэлтийн хувь	80.6		83.3		93.8	

Аймгийн ГХУСАЗЗ-ийн ажиллах журмын 1.2-д “Зөвлөлийн хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна” гэж заасан боловч 2015 онд 3 удаа, 2016 онд 3 удаа, 2017 онд 2 удаа хуралдсан байна.

Аймгийн ГХУСАЗЗ нь аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар, Тагнуулын газар, МХГ, БСГ, БОАЖГ, ОБГ-тай хамтран сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагаатай жилд 2-3 удаа танилцаж, арга зүйн туслалцаа үзүүлэх, хууль сурталчлах, сургалт зохион байгуулах чиглэлээр бүх сумдад ажилласан байна.

ГХУСАЗЗ-өөс хууль сахиулах байгууллагуудтай хамтран хүн ам ихээр суурьшсан Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын онцгой анхаарал татсан цэгүүд, замын хөдөлгөөн ихээр гардаг уулзвар, гүүрүүдийн орчим телекамер суурилуулах, олон нийтийн газар, гудамж талбай, байгууллагын орчны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, сумдад “Хөршийн холбоо”, “Малчдын бүлэг” зэрэг иргэдийн сайн дурын нөхөрлөлийг орон нутгийн онцлогт тохируулан байгуулж, ажиллуулах, “School police” эргүүлийг хэвшүүлэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт, сурталчилгааг зохион байгуулах зэрэг ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлжээ.

Гэвч дараах ажлууд хангалттай хэмжээгээр хийгдээгүй байна.Үүнд:

- Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах ажлыг зохион байгуулах талаар хууль сахиулах байгууллагуудтай хамтран дүн шинжилгээ хийх , шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг дутуу хэрэгжүүлэн зөвхөн хууль сахиулах байгууллагуудын хийж гүйцэтгэсэн ажлын тоон мэдээллийг үйл ажиллагааны тайландаа тусгасан байна.
- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагуудын идэвх, санаачлагыг өрнүүлэх, тэднийг энэ ажилд татан оролцуулах, идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг шагнаж, урамшуулах чиглэлийн ажлууд хангалтгүй байна.
- Зөвлөлөөс зохиож буй ажлын явц, үр дүнгийн талаар айл өрхүүд, иргэдийн дунд нийтлэг үйлчилгээ үзүүлдэггүй “Таны Сэлэнгэ” кабелийн телевизээс бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажил хийгдээгүй байна.

- Аймаг, сумын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын тайланг ЗДТГ-аас хагас, бүтэн жилээр гаргуулж, тэдний ажилд үнэлэлт дүгнэлт өгөх ажил тогтмолжоогүй байна.
- Сумдын ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаатай танилцах, хяналт шалгалт хийх, заавар зөвлөгөө өгөх ажлын хэсгүүдийг томилон ажиллуулж байгаа боловч ажилласан тухай илтгэх хуудас, үр дүнг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, баримт, материалуудыг бүрэн гүйцэд архивын нэгж болгон хадгалаагүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сургалт, сурталчилгааг олон тоогоор зохион байгуулж байгаа боловч энэ нь тодорхой тооны албан тушаалтнуудын хүрээг хамарч, гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий эмзэг бүлгийн иргэд, архидагчдыг сургалт, ухуулга, сурталчилгаанд хамруулах, энэ чиглэлийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах ажил тогтмолжиж чадаагүй байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 12.3 дахь заалтаар хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллуулах хүний тоо, урамшууллын хэмжээг ИТХ-аар жил тутам тогтоолгож, хэрэгжүүлэхээр хуульчлагдсан атал 2015 онд тогтоосон тоо хэмжээ, урамшууллыг өнөөг хүртэл шинэчлэн тогтоогоогүй, 2016 оноос эхлэн төсөв, санхүү хүрэлцээгүй гэсэн шалтгаанаар уг үйл ажиллагааг зогсоосон байна.

Аймгийн ГХУСАЗЗ-өөс сумдын ГХУСАЗСЗ-ийн 2015-2016 он, 2017 оны эхний хагас жилийн ажлыг шалгасан илтгэх хуудас, тайлангаас үзэхэд сумдын ГХУСАЗЗ нь хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай хамтран малын хулгай, архидалттай тэмцэх талаар тодорхой ажил зохион байгуулж байгаа боловч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарим сумдын нутгийн захиргааны байгууллагуудын оролцоо хангалтгүй, уг ажил нь зөвхөн цагдаагийн байгууллага, хэсгийн төлөөлөгчийн үүрэгт ажил мэтээр ойлгодог албан тушаалтнууд ч байгаа талаар дурдагдсан байна.

Бүлэг 3

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байна уу?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө хуульд заасан хэмжээнд төлөвлөгдөж байна уу?

Торгууль, шийтгэврийн орлогын 14.4 хувийг л гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял оногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40.0 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт


хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заалтыг мөрдөөгүй байна.

Шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах, торгох ял ногдуулснаар аймгийн Цагдаагийн газраас орон нутгийн төсөвт 2014 онд 44.1 сая төгрөг, 2015 онд 108.7 сая төгрөг, 2016 онд 266.1 сая төгрөг, сумдын орон нутгийн төсөвт 2014 онд 297.2 сая төгрөг, 2015 онд 424.5 сая төгрөг, 2016 онд 468.9 сая төгрөг зэрэг нийт 1,609.5 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Орон нутгийн төсөвт төвлөрсөн орлого, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хуваарилагдсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/

№	Он	Өмнөх оны орлого	Хуваарилвал зохих	Батлагдсан төсөв		зөрүү
				дүн	Нийт орлогод эзлэх хувь	
1	2015	341,3	136,5	104,2	30,5	32,3
2	2016	533,2	213,3	54,0	10,1	159,3
3	2017	735,0	294,0	74,4	10,1	219,6
	Нийт	1609,5	643,8	232,6	14,4	411,2

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төсвөөс хуваарилсан хөрөнгийн хэмжээг графикаар харуулбал:



Тайлант онуудад орон нутгийн төсөвт дээр дурдагдсан нийт 1,609.5 сая төгрөгийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 643.8 сая төгрөгийг зарцуулахаар хуульчлагдсан атал нийт төвлөрсөн орлогын 14.4 хувийг эзлэх 232.6 сая төгрөгийг төлөвлөсөн нь хуульд зааснаас даруй 411.2 сая төгрөгөөр бага байна.

Сумдын хувьд нийт 17 сумаас 15 нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 55.0 сая төгрөгийн орлого зарцуулахаар төлөвлөсөн бол Хүдэр сумын ИТХ 2015 онд, Цагааннуур сумын ИТХ 2015-2017 онд уг арга хэмжээнд ямар ч хөрөнгө төлөвлөөгүй байна. / сумдын орон нутгийн төсөвт төвлөрсөн торгуулийн орлого, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийг хавсралт 2-оор харуулав/

3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилт холбогдох хуулиудад нийцэж байна уу?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, батлан, хянахгүй байгаа нь батлагдсан санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 2015-2016 он, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар, нийт дүнгээр 232.6 сая төгрөгийн төсөв батлуулан, 188.0 сая төгрөгийг зарцуулж, Сангийн яамнаас зарцуулах эрх нээгээгүйгээс 2015 онд 16.5 сая төгрөг, 2016 онд 2.3 сая төгрөг зэрэг нийт 18.8 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн бөгөөд 2017 оны 3-р улирлын байдлаар 25.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

ГХУС зардлын төсвийн гүйцэтгэл /сая.төг/

№	Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зарцуулаагүй	үүнээс	
					төсөвт	үлдэгдлээр
1	2015	104.2	87.7	16.5	16.5	
2	2016	54.0	51.7	2.3	2.3	
3	2017.09 сар	74.4	48.6	25.8		25.8
	Нийт	232.6	188.0	44.6	18.8	25.8

Аймгийн ГХУСАЗЗ-ийн ажиллах журамд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, байгууллага, ААН, иргэдийн хандив, тусламжаар санхүүжүүлж болно гэж заасан хэдий ч зөвхөн төсвийн санхүүжилтээр эх үүсвэрийг бүрдүүлж, хандив, тусламжаар хөрөнгө төвлөрүүлэх талаар ямар ч ажил зохион байгуулаагүй байна.

Аймгийн ГХУСАЗЗ-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсвийг аймгийн ИТХ-ын тухайн жилийн төсөвт зардлын зүйл, бүлгээр бус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал гэсэн ангилалд бөөн дүнгээр хянаж, батлан, тайлагнуулж байгаа нь төрийн сангийн зүгээс зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сулруулж, батлагдсан санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.

3.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулагдсан төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байна уу?


Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах зөрчил оршсоор байна.

Аймаг, сумдын ГХУСАЗЗ нь 2015- 2016 он, 2017 оны 9 сарын байдлаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулсан байна. Зарцуулалтыг зардлын зүйлээр харуулбал:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөрөнгийн зарцуулалт / аймаг, сумын нийт, сая төг /

№	Зардлын төрөл	2015	2016	2017.09.30	Нийт
1	Сургалт сурталчилгаа	20.1	20.0	10.7	50.8
2	Эргүүл,жижүүр,олон нийтийн цагдаагийн урамшуулал	49.0			49.1
3	ГХУСАЗЗ-ийн ажилтны цалин, урамшуулал	8.5	10.1	6.4	25.0
4	Шатахуун	6.8	13.9	3.5	24.2
5	Иргэд ААН урамшуулал / сумд /	0.1	1.1	0.3	1.5
6	Техник хэрэгслийн зардал	1.9	4.1	27.0	33.0
7	Гэмт хэргийн талаар мэдээлэл /сумд /	0.1	0.1	0.2	0.4
8	ИТХ-ын урсгал зардал санхүүжүүлсэн /сумдууд /	1.2	2.4	0.5	4.1
	Нийт	87.7	51.7	48.6	188.0

**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан хөрөнгийн
бүтцийг графикаар харуулбал:**



Аймаг, сумдын ГХУСА33-үүд аудитад хамрагдсан хугацааны нийт төсвийн 27.0 хувийг сургалт сурталчилгааны зардалд, 26.1 хувийг эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтны урамшилд, 12.9 хувийг шатахуунд, 13.3 хувийг аймгийн ГХУСА33-ийн ажилтны цалин, урамшуулалд, 0.8 хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд идэвхтэй оролцсон иргэн ААН-ыг урамшуулахад, 17.6 хувийг цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгслийн зардлыг санхүүжүүлэхэд, 2.2 хувийг сумдын ИТХ-ын урсгал зардлыг санхүүжүүлэхэд, 0.2 хувийг иргэдээс мэдээлэл авах төлбөрийг санхүүжүүлсэн байна.

Аймгийн Цагдаагийн газрын хүсэлтийн дагуу шаардлагатай байгаа техник тоног төхөөрөмж авах, малын хулгайтай тэмцэх, баяр ёслолын үеэр болон Буриад улсын ерөнхийлөгчийн хамгаалалтын шатахуунд зориулж 2015 онд 12.1 сая төгрөг, 2016 онд 2.4 сая төгрөг нийт 14.5 сая төгрөгийг Засаг даргын нөөцөөс, 2017 онд 19.0 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас олгосон байна.

Аудитын явцад аймгийн ГХУСА33-ийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг зориулалтын бусаар зарцуулсан, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зэрэг дараах зөрчлүүд оршиж байна. Үүнд:

- *Зөвлөлийн гишүүдийн сумдад ажиллах замын маршрутыг холбогдох албан тушаалтнаар батлуулаагүй, жолоочийн замын хуудас хөтлөөгүй, шатахуун хүссэн өргөдөлд зардлын тоо хэмжээ, огноо, томилолтоор ажилласныг нотлох илтгэх хуудас бичигдээгүй, удирдамжийн болон маршрутын хугацаа нь зардал олгосон хугацаатайгаа зөрөх, шатахууны зардал хүлээн авсан хүний гарын үсэг зурагдаагүй зэрэг зөрчил нийтлэг байдалтай оршиж байгаагаас 2015 онд 4.3 сая төгрөг, 2016 онд 3.1 сая төгрөг, 2017 онд 1.8 сая төгрөг зэрэг нийт 9.2 сая төгрөгийн шатахууны зарцуулалт анхан шатны баримтаар нотлогдохгүй байгаа нь ГХУСА33-ийн батлагдсан төсвийг бусад үйл ажиллагаанд зарцуулсан байх эрсдэлтэй байна.*
- *УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2001 оны 01-р сарын 31-ны өдрийн 13 дугаар тогтоолын 3.6 –д “Аймаг нийслэл, дүүргийн ИТХТ-ийн ажлын албанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцсан орон тооны ажилтныг томилон ажиллуулах” гэж заасан атал ГХУСА33 –ийн нарийн*

бичгийн даргыг аймгийн ГХУСАЗЗ-ийн батлагдсан төсвөөс цалинжуулж, сар бүр 650.0 мянган төгрөгийн цалин олгож, 2015-2017 онуудад цалин, НДШ-ийн зардалд нийт 23.5 сая. төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19-р зүйл болон дээрх тогтоолыг зөрчсөн үйлдэл болжээ.

- Сургагч багшийн урамшууллыг харилцах дансанд нь гүйлгээ хийснийг банкаар баталгаажуулаагүйгээс 2015 онд 0.5 сая төгрөг, 2016 онд 0.8 сая төгрөг, 2017 онд 0.3 сая төгрөг зэрэг нийт 1.6 сая төгрөгийн урамшууллыг эзэнд нь олгосон эсэх нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.
- 2016 онд аймгийн ГХУСАЗЗ-ийн даргын шийдвэрээр зөвлөлийн гишүүдэд нийт 1.5 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.3-д заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн зарцуулах чиглэлийг зөрчсөн байна.

Сумдын хувьд Зүүнбүрэн, Сант, Сайхан, Сүхбаатар, Хүдэр, Шаамар сумд ГХУСАЗЗ-ийн батлагдсан төсвөөс ИТХ-ын урсгал зардлыг санхүүжүүлэхэд 4,1 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хэрхэн явагдаж байна вэ?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны батлагдсан төсвийн зарцуулалтад дотоод хяналт хийгдээгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.5 дахь заалтад “Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн ИТХ болон Төсвийн тухай хууль, тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина” гэж заасан байдаг боловч дээрх байгууллага, албан тушаалтны зүгээс хяналт, шалгалт хийгдээгүй байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчилд албан шаардлага бичигдлээ. Үүнд:

- Аймгийн ГХУСАЗЗ-ийн төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль, стандартын дагуу хөтлөөгүй, томилолтоор ажилласан тухай илтгэх хуудас, замын маршрут зэрэг шатахууны зарцуулалтын анхан шатны баримт зэрэг хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрдүүлээгүй ГХУСАЗЗ-ийн нягтлан бодогч П.Баярцэцэг, ажилтан С. Баяржаргал нарт сахилгын шийтгэл ногдуулах.
- Сумдын ГХУСАЗЗ-ийн батлагдсан төсвөөс ИТХ-ын хуралдааны зардалд гүйлгэн зарцуулсан 4.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх.
- Аймгийн ГХУСАЗЗ-ийн ажилтны цалинг аймгийн ИТХ-ын ажлын албаны төсвөөс бус ГХУСАЗЗ-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний батлагдсан төсвөөс олгож, зориулалт бусаар зарцуулсан 23.5 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.
- Сургагч багшийн урамшууллыг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр олгосон 1.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх.

- Шатахууны зарцуулалтыг анхан шатны баримтын бүрдэлгүй олгосноос бусад үйл ажиллагаанд зарцуулсан байх эрсдэлтэй 9.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх.
- Аймгийн ГХУСАЗЗ-ийн гишүүдэд урамшуулал олгож, зориулалт бус зардал гаргасан 1.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зэрэг нийт 39.9 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага бичигдлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цулуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн Цагдаагийн газрын “ Судалгаа, дүн шинжилгээний баг “ гэмт хэрэг гарч буй шалтгаан, нөхцөлийг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөн, гүйцэтгэж байна.
- Хорих ял эдлээд суллагдсан хүнд хуульд заасан журмын дагуу захиргааны хяналтыг тогтоон ажиллаж байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг тодорхой хэмжээгээр татан оролцуулж байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалтууд олон тоогоор зохион байгуулагдаж байгаа боловч эрсдэл бүхий эмзэг бүлгийн иргэдийг бүрэн хамруулж чадахгүй байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүйгээр гэмт хэргийн тоо буурах чиг хандлагагүй байна.
- Аймгийн ГХУСАЗЗ нь үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна.
- Торгууль, шийтгэврийн орлогын 14.4 хувийг л гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар төлөвлөсөн байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, батлан, хянахгүй байгаа нь зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг дагуулж байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсвийн зарцуулалтад дотоод хяналт хийгдэхгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Аймгийн ГХУСАЗЗ өвлөлийн дарга Г.Бямбаа болон сүмдын ГХУСАЗЗ-ийн дарга нарт :

- ГХУСАЗЗ-ийн төсвийг холбогдох орлогоос хуулинд заасан хувь хэмжээгээр байгуулж, батлуулах.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүрэг болон аймгийн ГХУСАЗЗ-ийн журамд заасан арга хэмжээг бүрэн төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллах.
- ГХУСАЗЗ-ийн хуралдааныг журамд заасан хугацаанд хуралдуулж байх.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12-р зүйлийн дагуу хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллуулах хүний тоо, урамшууллын хэмжээг жил тутам тогтоож, ажиллуулах.
- ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, сумдад ажилласан гишүүдийн тайлан, илтгэх хуудас, хурлын тэмдэглэл зэрэг үндсэн үйл ажиллагаатай холбоотой материалуудыг үдэж цэгцлэн, архивын нэгж болгон хадгалах.
- ГХУС ажил хариуцсан ажилтныг аймгийн ИТХ-ын ажлын албаны орон тоонд багтаан ажиллуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулах.
- ГХУС ажиллагааны батлагдсан төсвийн хэрэгжилт, зарцуулалтад хяналт тавих.

2. Нягтлан бодогч П.Баярцэцэгт:

- Аймгийн ГХУСАЗЗ-ийн батлагдсан төсвийн зарцуулалт, ялангуяа шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.
- Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль, эрхийн акт, стандартын дагуу хөтлөх, анхан шатны баримтын бүрдлийг хангах.
- Шатахууны картыг байгууллагын няравт эзэмшүүлж, хуулгыг харилцагч НИК компаниар гаргуулан, санхүүгийн баримтад хавсаргахын зэрэгцээ замын маршрутыг тухай бүрд нь хийж, шатахууны зардлыг томилолтоор ажиллах албан тушаалтанд хүлээлгэн өгч, баталгаажуулах.
- Сургагч багш болон бусдад олгосон ажлын хөлсийг хүлээн авсан хүний гарын үсэг, харилцагч банкны гүйлгээ хийсэн жагсаалтаар баталгаажуулж байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Б.НАРАНЧИМЭГ

6. Үндсэн мэдээлэл

УИХ-аас 1997 онд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” баталсан бөгөөд 2012 оны 01 дүгээр сарын 19, 2013 оны 07 дугаар сарын 05, 2015 оны 12 дугаар сарын 04, 2016 оны 12 дугаар сарын 22, 2017 оны 05 дугаар сарын 18-нд буюу нийт 5 удаа уг хуульд өөрчлөлт оруулсан байна.

нийт үйлдэгдсэн гэмт хэрэгт хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 30,5-39,9 хувийг, хулгайн гэмт хэрэг 23,4-26,2 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр бөгөөд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын гэмт хэргийн тоо нэмэгдэх хандлагатай байна.

Судалгаа дүн шинжилгээний баг нь гэмт хэрэг гарч байгаа нөхцөл шалтгаан, шинж чанарт судалгаа, шинжилгээ хийснээр гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан нөхцөлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Архидалт ихэссэн,
- Тээврийн хэрэгсэлийн тоо нэмэгдэж, замын хөдөлгөөн ихэссэн, хөдөлгөөнд тавих хяналт, ажиллах хүн хүч, техник хэрэгсэл дутмаг,
- Төсөв мөнгөний хүрэлцээгүй,
- Сумдын ГХУС зөвлөлийн ажил хангалтгүй,
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, харуул хамгаалалт, сонор сэрэмж сул,
- Алсдагдсан газруудад гэрэлтүүлэггүй, хяналтын камерын хүрэлцээ дутмаг,
- Ажилгүйдэл, ядуурал өссөн,